

Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон
түүний харьяа байгууллагад хандаж гаргасан
иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар
танилцуулга

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд тус яам болон түүний харьяа байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2024 оны 1 дүгээр улирлын тайлан, дүн мэдээг танилцуулж байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон түүний харьяа байгууллагад 2024 оны 1 дүгээр улиралд иргэдээс нийт **5,025** өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэн байна. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг байгууллага тус бүрээр авч үзвэл:

- 1.Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 18;
- 2.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт 1;
- 3.Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газарт 4519;
- 4.И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газарт 487.

Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Радио, телевизийн үндэсний сүлжээ улсын төсөвт үйлдвэрийн газар, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв улсын төсөвт үйлдвэрийн газарт хандаж, өргөдөл, гомдол ирээгүй байна.

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд салбарын хэмжээнд 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт **5,025** өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн **5,006** буюу **99.6** хувь нь хянан шийдвэрлэгдэж, хариу өгөх хугацаа болоогүй 19 буюу 0.4 хувь судлагдаж байна. 2024 оны 1 дүгээр улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,917 буюу 1.3 дахин хувиар нэмэгдсэн байна.

Иргэд, олон нийттэй харилцах төв (11-11) утсаар болон уг утасны 2 дахь шугамын дуудлагаар 501, бичгээр 276, цахимаар 3,047, байгууллагын утсаар 1,201 иргэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтээ илэрхийлсэн байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон түүний харьяа, салбар байгууллагууд нь иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн хугацааг баримтлан иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг барагдуулж байна.

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

Өргөдөл, гомдлын тайлан
/2024 оны 1 дүгээр улирлын байдлаар/

Д/д	Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл				Хүлээн авсан хэлбэр				
		Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр
		1	2	3	4	5	6	7	8	9
1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	0	8	3	7	0	1	0	13	4
2	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	0	1	0	0	0	0	0	1	0
3	И-Монгол академи УТҮГ	0	26	5	456	0	0	0	487	0
4	Үндэсний дата төв УТҮГ	0	0	0	4519	0	1200	3047	0	272
	Нийт	0	35	8	4982	0	1201	3047	501	276

Шийдвэрлэлтийн байдал

Д/д	Байгууллагын нэр	Шийдвэрлэж хариу өгсөн				Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн тоо /30 хоног/	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн тоо /60 хоног/	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй
		Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо				
		1	2	3	4	5	6				
1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	3	3	7	1	2	0	0	0	4	0
2	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	0	1	0	0	0	0	0	0	0	0
3	И-Монгол академи УТҮГ	0	0	472	0	0	0	0	0	15	0
4	Үндэсний дата төв УТҮГ	25	3294	1200	0	0	0	0	0	0	0
	Нийт	28	3298	1679	1	2	0	0	0	19	0